



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/166

Чингис хот

Коронавируст халдварын тархалтын
“Улбар шар” түвшинд шилжсэнтэй холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/12 дугаар тушаал, Аймгийн Онцгой комиссын 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт /COVID-19/-ын батлагдсан тохиолдлын тархалтад хийсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх сумдыг бүх нийтийн бэлэн байдлын зэргээс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /улаан түвшнээс улбар шар түвшинд/ шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улаанбаатар хот, аймаг, сумдын хооронд хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт, эрүүл мэнд, аргэрийн гачигдал, хүнс тээвэр/-аас бусад орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 хүртэлх хугацаанд зогсоож холбогдох дүрэм, журмыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Улаанбаатар хот болон халдварын голс мотот бүсээс уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ирсэн иргэдийг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, аймгийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхдээ болон ажиглалтын 7 хоног дууссаны дараа түргэвчилсэн оношлуураар төлбөртэй шинжилгээ авах ажлыг зохион байгуулахыг сумын Онцгой комисст, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/-т үүрэг болгосугай.

4. Халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх, Баянхутаг сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албад, тусгай чиг үүрэг гүйцэтгэх төрийн байгууллага бүрэн бүрэлдэхүүнээр, бусад төрийн байгууллага 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл 30 хүртэл хувийн бүрэлдэхүүнтэйгээр богиносгосон цагаар /09:00-12:00, 14:00-17:00/ ажиллуулахыг төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Сүхбаатар аймагт коронавируст халдвар /COVID-19/-ын тохиолдол батлагдсан тул хил залгаа орших Баян-Овоо, Баянхутаг, Галшар сумд тус аймгийн сумдаас орох

231011597

хөдөлгөөнийг хязгаарлаж хяналтын цэг байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Баянхутаг сумдын коронавируст халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдлын ойрын хавьтлаар бүртгэгдсэн иргэдийг гэр бүлийн хамт 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл гэрийн ажиглалтад авч, хяналт тавьж ажиллахыг сумдын Онцгой комисст үүрэг болгосугай.

7. Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх, Баянхутаг сумдын бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл түр зогсоосугай.

8. Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх, Баянхутаг сумдын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй банкны салбар, бараа, барилгын материалын дэлгүүр, ахуй үйлчилгээний газар /гэрэл зургийн үйлчилгээ, цаг засвар, гар утас засвар, оёдолчин, үсчин гоо сайхан, гутал засвар, халуун усны газар/, авто сэлбэгийн худалдаа, авто машин угаалга зэрэг газруудыг 10:00-17:00 цаг, хүнсний дэлгүүр, өөртөө үйлчлэх хоолны газар /буфет/, зоогийн газруудын цагийн хуваарийг 09:00-18:00 цаг, зочид буудал, дэн буудал, дугуй засварын үйл ажиллагааг цагийн хэвийн горимоор ажиллуулж, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж түр журмын хэрэгжилтийг хангасан аж ахуйн нэгжид зөвшөөрөл өгч ажиллуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

9. Аймгийн нутаг дэвсгэрт голомт бүхий объект, байршилд халдваргүйжүүлэлтийн ажлыг шат дараатай зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Зооноз өвчин судлалын төв /Г.Наранхүү/, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/ нарт тус тус даалгасугай.

10. Хэнтий аймгийн хэмжээнд архи, сог'ууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйлчилгээ, олон нийтийг хамаарсан хурал зөвлөгөөн, жагсаал цуглаан, соёл урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах, сургалтын төв, фитнес бялдаржуулах төв, спорт зал, баар, караоке, компьютер болон биллиард тоглоомын газар, сүм хийдийн үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл зогсоосугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ